



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/44

Шивээговь сум

Хяналтын цэг ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.в, 29.1.6.а, б, л, 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.8, Улсын Онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/91 дүгээр захирамж, сумын Онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 07 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Монгол Улсад коронавируст халдвар (COVID-19)-ын анхны батлагдсан тохиолдол Бүгд найрамдах Франц Улсаас зөөвөрлөгдөн орж ирсэн тул халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор сумын төвөөс орох, гарах тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг хянах хяналтын цэгийг 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 07:00 цагаас 03 дугаар сарын 16-ны өдрийн 07:00 цаг хүртэлх хугацаанд ажиллуулсугай.

2. Хяналтын цэгийн ажиллах хуваарийг хавсралт ёсоор баталсугай.

3. Сум, аймаг, хот хоорондын хүнсний болон бусад ачаа тээвэрлэлтийг хэвийн явуулах, хүндэтгэн үзэх шалтгааны улмаас /ар гэрийн гачигдал, эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ, албан томилолт, харуул манаа, ээлж солилцох, Хөдөлмөрийн тухай хуулийн 74.2-т заасан хойшлуулшгүй яаралтай ажил гүйцэтгэх гэх мэт/ зорчих иргэд, ажилтан, албан хаагчийн нотлох баримтыг үндэслэн хүндрэл чирэгдэл учруулахгүйгээр нэвтрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг сумын Цагдаагийн хэсгийн дарга, онцгой комиссын гишүүн, цагдаагийн хошууч /Ц.Баасанжав/, Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, шуурхай штабын дарга /Б.Баасанбат/ нарт үүрэг болгосугай.

4212 01 2

4. Хяналтын цэгт ажиллаж байгаа ажилтнуудын аюулгүй байдлыг хангаж, эм эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодис, амны хаалтаар хангах, цалин хөлс, томилолтын зардлыг тооцож олгохыг байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч, Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дарга /Ж.Батмөнх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ

Сумын Засаг даргын 2020 оны 03-р сарын 10-ны өдрийн 44 дугаар захирамжийн хавсралт



СУМЫН ТӨВӨӨС ОРОХ, ГАРАХ ХӨДӨЛГӨӨНИЙГ ХЯНАХ,
ХЯНАЛТЫН ЦЭГ /ТӨВ ЗАСМАЛ ЗАМ/ ДЭЭР АЖИЛЛАХ
ЦАГИЙН ХУВААРЬ

2020.03.10

№	Цагдаагийн албан хаагч	Эрүүл мэндийн төвийн албан хаагч	Төрийн албан хаагч, ажилтан	Ажиллах сар, өдөр	Цаг, минут	Утасны дугаар
1	Сумын Цагдаагийн хэсгийн алба хаагчид	ЭМТ-ийн даргын тушаалаар батлагдсан, хуваарьт заагдсан нэр бүхий албан хаагчид	ЗДТГ А.Нандинцэцэг	III/10	08 ⁰⁰ -III/11-ний өдрийн 08 ⁰⁰	99538193
2			ЗДТГ О.Отгонбаяр	III/11	08 ⁰⁰ -III/12-ны өдрийн 08 ⁰⁰	86133909
3			ШОХК Э.Очирсүрэн	III/12	08 ⁰⁰ -III/13-ны өдрийн 08 ⁰⁰	99907797
4			ЕБС Ш.Бат-Амгалан	III/13	08 ⁰⁰ -III/14-ний өдрийн 08 ⁰⁰	94060209
5			ЕБС Ж.Амартүвшин	III/14	08 ⁰⁰ -III/15-ны өдрийн 08 ⁰⁰	86268279
6			ШОХК Э.Очирсүрэн	III/15	08 ⁰⁰ -III/16-ны өдрийн 07 ⁰⁰	99907797